



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар A/80

Мөрөн сум

Өмчлөлийн газрын хэмжээ өөрчлөх тухай

Монгол улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 Монгол улсын Хаягжуулалтын тухай хуулийн 4.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан "Гудамж, зам талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах тухай" журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2009 оноос геодезийн байрлал, өндрийн нэгдсэн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор туузан метрээр хэмжиж тодорхойлсон, кадастрын зурагт тэмдэглэгдсэн байршил, газрын талбайн хэмжээ нь нарийвчилсан хэмжилтээр зөрүүтэй гарах тохиолдлууд гарч байгаатай холбогдуулан газрын хэмжээ, хаяг өөрчлүүлэх хүсэлт гаргасан 1 иргэний хүсэлтийн дагуу газрын хэмжээ, хаягийг өөрчлөн хавсралтаар өмчлүүлсүгэй.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2005 оны 18 дугаар захирамжийн хавсралтын 12 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3.Холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж гэрчилгээ олгохыг Газрын даамал (Д.Нямцэцэг)-т даалгасугай.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ХАТАНБААТАР